



ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ  
ОДОН ОРОН, ГЕОФИЗИКИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Хүрээлэнгийн “Ёс зүйн дүрэм” батлах,  
“Ёс зүйн дэд хороо” байгуулах тухай

Монгол Улсын 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйл, БШУЯ-ны 2023 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 2/4409 дугаартай албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүрээлэнгийн “Ёс зүйн дүрэм”-ийг Хавсралт 1-ийн дагуу баталсугай.
2. Хүрээлэнгийн ажилтан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж, шийдвэр гаргах эрх бүхий “Ёс зүйн дэд хороо”-г дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга: А.Мөнхсайхан/Эрдэмтэн нарийн бичгийн дарга/

Гишүүд:

- |                |  |
|----------------|--|
| Д.Баатархүү    | /Астрофизикийн лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан/  |
| Н.Болортуяа    | /Астропаркийн лаборант/  |
| Ц.Нямбаяр      | /Газар хөдлөл судлалын салбарын геодинамик, сейсмо тектоникийн лабораторийн эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан/ |
| Ш.Цэрэндүг     | /Соронзон судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан/  |
| Ч.Оюунбилэг    | /Даланзадгад салбарын эрхлэгч, эрдэм шинжилгээний ажилтан/   |
| 3.Түвшинжаргал | /Ерөнхий нягтлан бодогч/   |

3. “Ёс зүйн дүрэм”-ийг 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн Хүрээлэнгийн хэмжээнд мөрдөх, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, тайлагнахыг Ёс зүйн дэд хорооны дарга /А.Мөнхсайхан/-т даалгасугай.

ЗАХИРАЛ



Ч.ОДОНБААТАР

01 / 10335

Одон орон, геофизикийн  
хүрээлэнгийн захирлын  
2025 оны 11 дүгээр сарын  
10-ны өдрийн А/186 тоот  
тушаалын хавсралт 1

## ШУА-ИЙН ОДОН ОРОН, ГЕОФИЗИКИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. ШУА-ийн Одон орон, геофизикийн Хүрээлэн (цаашид Хүрээлэн гэнэ)-ийн хэмжээнд эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажил гүйцэтгэх болон уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах чиг үүрэг бүхий үйлчилгээний ажлуудыг гүйцэтгэхэд дагаж мөрдөх ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, үндсэн чиг үүргээ нэр төртэй, хариуцлагатай биелүүлэхийн тулд ажилтан нь тогтоосон ёс суртахууны зарчим, хэм хэмжээг мөрдлөг болгох, ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.
- 1.2. Энэхүү дүрэм нь Хүрээлэнгийн хэмжээнд одоо ажиллаж байгаа нийт эрдэм шинжилгээний ажилтан, ажиллагсад, удирдах ажилтан (цаашид нийтэд нь Ажилтан гэнэ) хамаарна.
- 1.3. Эрдэм шинжилгээний ажилтан гэдэгт Хүрээлэнгийн хэмжээнд судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэж буй нийт эрдэм шинжилгээний ажилтан судлаачид хамаарна.
- 1.4. Ажиллагсад гэдэгт Хүрээлэнгийн хэмжээнд ажиллаж байгаа захиргаа санхүүгийн нийт ажилтан, ажилчид хамаарна.
- 1.5. Удирдах ажилтан гэдэгт шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтнууд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, салбарын дарга нар, орон нутаг дах салбарын эрхлэгч нар хамаарна.
- 1.6. Хүрээлэн нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий Ёс зүйн дэд хороотой байна.

### Хоёр. Дүрмийн нэр томьёо

Дүрэмд орсон нэр томьёоны тайлбар:

- 2.1. "Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй" гэж шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны хүрээнд эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлыг гүйцэтгэх арга, зан үйл, харилцааны дэг журмыг багтаасан үйлдэл, эс үйлдлийн нийлбэр цогцыг хэлнэ.
- 2.2. "Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээ" гэж эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг хариуцлагатай, үнэнч шударга гүйцэтгэх мэргэжлийн хариуцлага, үйл ажиллагааны нийтлэг шаардлагыг илэрхийлсэн үйлдэл, эс үйлдлийг хэлнэ.
- 2.3. "Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн зөрчил" гэж эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил эрхлэх тухай мэдээлэл хийхээс эхлээд судалгааг явуулах, судалгааны дүнг нэгтгэн хэлэлцэх, үр дүнгийн тайлан бичих үндсэн үе шатуудад бодит үр дүн мэдээллийг санаатайгаар зохиох, өөрчлөх, бусдын ажлын үр дүнг хуулбарлах, ажил хэргийн гэрээ, хэлэлцээрийг үндэслэлгүйгээр зөрчих үйлдлийг хэлнэ.

2.4. "Эрдэм шинжилгээний ажилтны үйл ажиллагааны ёс зүйн зарчим" гэж шинжлэх ухааны салбар, байгууллагын онцлогоос үл хамааран шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхэлж буй мэргэшсэн судлаач бүр чанд баримтлах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээг хэлнэ.

2.5. "Эрдэм шинжилгээний хамтлаг, судлаачдын баг" гэж шинжлэх ухаан, технологийн төсөл, шинжлэх ухааны суурь судалгааны сэдэвт ажлыг гүйцэтгэхэд хамтран ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтны бүлгийг хэлнэ.

2.6. "Эрдэм шинжилгээний бүтээлийн хэлэлцүүлэг" гэж магистрын дипломын ажил, боловсролын доктор (Ph.D), шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг горилсон бүтээл, эрдэм шинжилгээний ном, товхимол, судалгааны ажлын тайланг эрдмийн хамт олны хурлаар хэлэлцэхийг хэлнэ.

### **Гурав. Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим**

#### **3.1. Ажилтны баримтлах нийтлэг зарчим**

Хүрээлэнгийн ажилтан нь төрийн албыг хэрэгжүүлэхдээ ёс зүйн дор дурдсан нийтлэг зарчмыг баримтална.

3.1.1. Хуулиар олгогдсон эрхээ эдлэх, хэрэгжүүлэхдээ бусдын нэр төр, алдар хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг эрхэмлэн хүндэтгэнэ.

3.1.2. Албан үүргээ зохих ёсоор биелүүлж, төрийн албаны нэр хүндийг дээдэлнэ.

3.1.3. Хувийн үзэл бодол итгэл үнэмшил, шашин, улс төр, нийгмийн байр сууриа бусад ажилтан, хамт олонд тулган хүлээлгэх, нөлөөлөхгүй байна.

3.1.4. Төрийн албаны захирах, захирагдах ёсыг сахин биелүүлнэ.

#### **3.2. Эрдэм шинжилгээний ажилтны баримтлах зарчим**

Эрдэм шинжилгээний ажилтан нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэхдээ ёс зүйн дор дурдсан нийтлэг зарчмыг баримтална.

3.2.1. Хувь хүн бусад судлаач, тэдгээрийн үзэл бодлыг хүндэтгэн үзэх;

3.2.2. Шинжлэх ухааны танин мэдэхүй, нийгмийн практикт үр өгөөжтэй үйл ажиллагаа явуулах;

3.2.3. Үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажил явуулахгүй байх

3.2.4. Шинжлэх ухааны мэдээ баримт, тооцоо, дүн шинжилгээ, үндэслэл, үнэлгээ дүгнэлт нь нотолгоонд тулгуурлах;

3.2.5. Шинжлэх ухааны ололт, үр дүн, дүгнэлт нь улс төр, үзэл суртал, шашны үзлийн нөлөөллөөс ангид, гагцхүү шинжлэх ухааны үнэнийг дээдэлсэн байх;

3.2.6. Мэдлэг оюуны салбар дахь нийт хүн төрөлхтний болон үндэсний уламжлалт ёс заншлыг баримтлах


3.2.7. Био ёс зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг сахих

### **Дөрөв. Ажилтны ёс зүй**

#### **4.1. Хүрээлэнгийн ажилтны нийтлэг дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээ**

4.1.1. Ажилтан нь хувь хүн, хамт олныг үг хэлээр гутаан доромжлох, дорд үзэх, бусдын нэр хүндийг унагаахгүй байх.

4.1.2. Ажилтан нь хувь хүн, хамт олны нууцтай холбоотой мэдээллийг хууль бусаар ашиглах бусдад дамжуулахгүй байх.



4.1.3. Ажилтан нь мэргэжил, албан тушаалын давуу талаа ашиглан бусдыг бие махбодь, сэтгэл зүйн болон санхүүгийн дарамтад оруулахгүй байх.

4.1.4. Ажилтан нь жендерийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх.

4.1.5. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэх, байгууллагын дотоод

журмыг мөрдөх.

4.1.6. Төрийн алба хаах хугацаанд төрийн бодлого үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ мэдээлэл тараахгүй байх.

4.1.7. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр зөвхөн Хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэх.

4.1.8. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх, албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатай нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх.

4.1.9. Удирдлагадаа байгаа албан хаагчийг айлган сүрдүүлэх, доромжлох, хясан боогдуулах зэргээр албаны хэвийн харилцааг алдагдуулах, хууль бус үүрэг даалгавар өгөхгүй байх.

#### 4.2. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээ

4.2.1. Зөвхөн шинжлэх ухааны үнэнийг эрж олох, баталгаажуулах, нийтэд түгээн дэлгэрүүлэхийг эрхэмлэнэ.

4.2.2. Хүний хөгжил, хүмүүнлэг үйлсийн төлөө зорилгод захирагдан туршилт, зохион бүтээх үйл ажиллагааг эрхэлнэ.

4.2.3. Бусад судлаачийн үзэл баримтлалыг хүндэтгэх, ойлгох, мөн өөрийн үзэл баримтлалыг бусдад зөв ойлгуулахдаа байгууллага, хувь хүний нэр төрд халдах, гүтгэх, доромжлохыг цээрлэнэ.

4.2.4. Судалгааны ажилдаа үнэнч, чин сэтгэлээсээ хандаж, судалгаа, шинжилгээний зориулалттай нийтийн эзэмшлийн техник, тоног төхөөрөмжийг зөвхөн зориулалтын дагуу ашиглана.

4.2.5. Судалгааны ололт, үр дүнг хүн, нийгмийн эсрэг болон хувийн явцуу зорилгод урвуулан ашиглахыг цээрлэнэ.

4.2.6. Бусдын бүтээл, судалгааны үр дүнг үндэслэлгүй шүүмжлэх, шүүмжлэлийг шинжлэх ухааны бус аргаар өрнүүлэхээс татгалзаж, үнэнийг үл өмчилнө.

4.2.7. Эрх мэдэл, нэр төр, албан тушаалын байр сууринаас эрдэм шинжилгээний ажилд хандахыг цээрлэнэ.

#### 4.3. Эрдэм шинжилгээний хамтлаг, судлаачдын багт ажиллах ёс зүйн хэм хэмжээ, хариуцлага

4.3.1. Эрдэм шинжилгээний хамтлаг, судлаачдын багт судлаач зөвхөн өөрийн саналын үндсэн дээр орж ажиллана. Хамтлаг, багийг бүрдүүлж байгаа субъект санал болгосон байх ёстой.

4.3.2. Хамтлаг, багт ажиллахдаа гэрээ, хэлэлцээрийн шаардлагыг хатуу баримтална.

4.3.3. Хамтын судалгааны явц, үр дүнгийн талаарх мэдээллийг хамтлаг, багийн зөвшөөрөлгүйгээр нийтэлж, түгээж болохгүй.

4.3.4. Судалгааны ажлын явц, үр дүнгийн төлөө хамтын хариуцлага хүлээнэ.

4.4. Эрдэм шинжилгээний бүтээлийн хэлэлцүүлэгт судлаачийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ, хариуцлага

4.4.1. Эрдэм шинжилгээний бүтээлийн хэлэлцүүлэгт оролцох үүрэг хүлээсэн бол аль болох биечлэн оролцохыг хичээнэ.

4.4.2. Хэлэлцэж буй бүтээлтэй бүрэн танилцсаны үндсэн дээр саналаа илэрхийлнэ.

4.4.3. Хэлэлцүүлэгт оролцохдоо танил тал, байгууллагын харьяалал, багш шавийн холбоо зэргээс үл хамааран гагцхүү шинжлэх ухааны ёс зүйн шаардлагыг баримтална.

4.4.4. Хэлэлцүүлгийн явцад гардаг маргаан мэтгэлцээнд оролцохдоо бусдыг доромжлох, сэтгэл зүйн хувьд дарамтлах, баримт нотолгоогүй хуурай үгүйсгэл зэрэг үйлдэл гаргахаас зайлсхийнэ.

4.5.5. Хэлэлцүүлгийн өмнө болон явцад нь хэлэлцэж буй бүтээлийн талаар хувийн санаа бодлоо бусдад тулгах, далдуур хуйвалдах үйл ажиллагаа явуулахыг цээрлэнэ.

4.5.6. Хэлэлцүүлэгт орсон судлаач шаардлагатай гэж үзвэл хэлэлцүүлгийн тэмдэглэлтэй танилцаж гарын үсгээ зурж баталгаажуулж болно

#### **Тав. Ёс зүйн дэд хороо**

5.1. Ажилтан нь ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн эсэх асуудлаар эцэслэн дүгнэж шийдвэр гаргах эрх бүхий Хүрээлэнгийн Ёс зүйн дэд хороо нь 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр Хүрээлэнгийн Захирлын тушаалаар 5 жилийн хугацаатай томилно.

5.2. Ёс зүйн дэд хорооны зорилго нь ажилтны нэр хүнд, эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэхэд чиглэнэ.

5.3. Ажилтан ёс зүйн зөрчил гаргасан талаар хувь хүн, байгууллага аж ахуйн нэгжийн гомдол, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд нийтлэгдсэн мэдээ болон тухайн байгууллагын ажилтан, хамт олноос ирүүлсэн өргөдөл гомдол, дотоод хяналт шалгалтаар илэрсэн мэдээ баримт нь шалгалт явуулах үндэслэл болно.

5.4. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай мэдээллийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор дараах журмын дагуу шалгалт явуулна.


5.4.1. гомдол, мэдээлэлд холбогдсон ажилтан болон гомдол мэдээлэл гаргагчтай уулзаж, тэдгээрийн тайлбар, саналыг сонсож тэмдэглэл хөтлөх.

5.4.2. шаардлагатай гэж үзвэл бусад байгууллагаас баримт бичиг, тайлбар бусад лавлагаа материалыг гаргуулж авах.

5.4.3. харьяалах нэгжийн удирдлага, ажилтнуудтай уулзаж шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулах.

5.6. Ажилтан нь ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн нь шалгалтаар тогтоогдвол Хүрээлэнгийн Ёс зүйн дэд хорооны хурлаар хэлэлцүүлнэ.

5.7. Ёс зүйн дэд хорооны хуралдаанд зөрчилд холбогдсон албан хаагчийг биечлэн оролцуулж тайлбарыг сонсож, асуулт тавьж, хариулт авч болно.



5.8. Хуралд хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэж, хурлын тэмдэглэл хөтөлж, тэмдэглэлд Зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

5.9. Ёс зүйн дэд хорооны хуралдаанаар зөрчлийн шинж байдлыг харгалзан зөрчил гаргагчид дараах хариуцлагын төрлөөс сонгож шийтгэл оногдуулсан тогтоол гаргана. Үүнд:

5.9.1. уучлал гуйх

5.9.2. сануулах

5.9.3. гэмт хэргийн шинжтэй бол холбогдох байгууллагад шилжүүлэх

5.10. Ёс зүйн дэд хорооны тогтоолыг зөрчил гаргасан ажилтанд танилцуулна.

5.11. Ёс зүйн дэд хороо нь тухайн ажилтанд ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол мэдээлэл гаргагчид энэ тухай бичгээр хариу өгнө.

5.12. Ажилтанд хариуцлага хүлээлгэсэн шийдвэрийг тухайн ажилтны хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулан мэдээлнэ.

### **Зургаа. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйг хангах баталгаа**

6.1. Энэхүү дүрмийн хэрэгжилтийг хангах нь судлаач хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, эрдэм шинжилгээний ажилтны нэр төрийг цэвэр ариун байлгах баталгаа болно.

6.2. Ёс зүйн зөрчил гаргасан нь нотлогдсон судлаачид Ёс зүйн дэд хорооны шийдвэрийн дагуу энэхүү дүрмийн 5.6.-д заасан хариуцлагаас гадна тухайн ажилтны зэрэг дэв бууруулах шийтгэл ногдуулах асуудлыг эрдэм шинжилгээний байгууллагын аттестатчиллын комисст санал оруулж, Захирлын тушаалаар баталгаажуулна. Мөн судлаач ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд төсөл, сэдэв, грант авах эрхийг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авч болно.

6.3. Ёс зүйн зөрчил гаргаж шийтгэл хүлээсэн судлаач нь засарсан тухайгаа эрдмийн хамт олны өмнө үйл ажиллагаагаараа илэрхийлж, шийтгэлээ арилгуулахыг хүссэн тохиолдолд 2 жилийн дараа аттестатчиллын комисс болон эрдмийн зөвлөл авч хэлэлцэж болно.